

# “УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ” ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл,  
санхүүгийн зөвлөгөө, сургалт,  
үнэлгээний итгэмжлэгдсэн  
байгууллага



# “ULAANBAATAR AUDIT CORPORATION” LLC

Auditing, Accounting,  
Consulting, Training  
and Appraisal firm

2012 оны ᠒ᠡ дугаар  
сарын ᠒᠖-ны өдөр

Дугаар ᠑/᠒-᠐᠖᠖

Утас: 321844, 329430, 70110744  
Факс: 976-11-321844  
Шуудан: “Mongol Post” LLC  
Имэйл хаяг: ubaudit\_corp@mongol.net  
Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “МУДИКС” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

#### Оршил

Бид “МУДИКС” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2011 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх баланс, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “Санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

#### *Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага*

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

#### *Аудиторын хүлээх хариуцлага*

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хууль, Аудитын олон улсын стандарт, Үндэсний аудитын газраас баталсан “Санхүүгийн аудитын гарын авлага”-ын дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

#### *Цар хүрээ*

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг гүйцэтгэх үүднээс компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд удирдлагын хийсэн томоохон тооцооллууд болон баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үнэлэх ажлууд багтана.

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

*Дүгнэлт*

Бидний дүгнэлтээр, “МҮДИКС” ХК-ийн 2011 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:



Б.ОСОРГАРАВ

(Монгол Улсын гавъяат эдийн засааг,  
Монгол Улсын шилдэг няатлан бодогч,  
Монгол Улсын шилдэг менежер,  
Монгол Улсын шилдэг маркетер)

**БАЛАНС**

2011 оны 12 сарын 31-ны байдлаар

(Мянган төгрөгөөр)

<b>БАЛАНСЫН ЗҮЙЛ</b>	<b>Тодотгол</b>	<b>2010.12.31</b>	<b>2011.12.31</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,232.7	64,740.1
Дансны авлага	4	11,980.4	418,911.0
Бараа материал	5	21,304.2	21,546.0
Урьдчилж төлсөн зардал / тооцоо		2,488.9	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>37,006.2</b>	<b>505,197.1</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө /цэвэр/	6	-	948.7
Биет бус хөрөнгө/цэвэр/		-	-
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>-</b>	<b>948.7</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>37,006.2</b>	<b>506,145.8</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
<b>Өр төлбөр</b>			
Богино хугацаат өр төлбөр	7	11,313.4	444,995.6
Урт хугацаат өр төлбөр		-	-
<b>Өр төлбөрийн дүн</b>		<b>11,313.4</b>	<b>444,995.6</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>			
Хувийн өмч	8	37,175.7	38,569.2
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг/алдагдал/	9	(11,482.9)	22,581.0
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>25,692.8</b>	<b>61,150.2</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>37,006.2</b>	<b>506,145.8</b>

Нэмэлт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

**ОРЛОГЫН ТАЙЛАН**

2011 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодотгол	2010.12.31	2011.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>			
Борлуулалтын орлого	10	-	1,067.3
Бусад орлого	10	-	58,166.8
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-	-
<b>Нийт ашиг</b>		-	<b>59,234.1</b>
Үйл ажиллагааны зардал	11	-	29,743.2
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал</b>		-	<b>29,490.9</b>
Торгууль, хөнгөлөлтийн ашиг/алдагдал/		-	-
Вальютын ханшийн өөрчлөлтийн зөрүүний ашиг/алдагдал/	12	-	(1,093.2)
Вальютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг/алдагдал/		-	-
Бусад		-	-
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал</b>		-	<b>(1,093.2)</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал</b>		-	<b>28,397.7</b>
Орлогын татварын зардал	13	-	(5,816.7)
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		-	<b>22,581.0</b>

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг саллигүй хэсэг болно

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2011 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нооц	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2009 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл</b>	<b>37,175.6</b>	-	-	<b>(11,482.9)</b>	<b>25,692.7</b>
Тайланг үеийн цэвэр ашиг				-	-
Өмчийн дахин үнэлгээний бууралт				-	-
Гаргасан хувьцаат капитал				-	-
<b>2010 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>37,175.6</b>	-	-	<b>(11,482.9)</b>	<b>25,692.7</b>
Залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт/	38,569.2				38,569.2
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/гарз/	(37,175.6)			11,482.9	(25,692.7)
Тайланг үеийн цэвэр ашиг	-			22,581.0	22,581.0
Ногдол ашиг	-			-	-
Гаргасан хувьцаат капитал	-			-	-
<b>2011 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>38,569.2</b>	-	-	<b>22,581.0</b>	<b>61,150.2</b>

Нэмэлт тодотголдууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно

РАС/13

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(Мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31	2011.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	-	<b>1,382.8</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	-	1,067.3
Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад	-	315.5
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	-	<b>417,830.6</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	-	4,680.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	-	390.6
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	-	21,546.0
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	-	4.0
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	-	390,918.9
Төлсөн хүү	-	-
Төлсөн орлогын татвар	-	291.1
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	-
Бусад	-	-
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(417,830.6)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого	-	-
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	-	(1,035.0)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(1,035.0)</b>
Мөнгөөр эргүүлж худалдан авсан хувьцаа	-	38,569.2
Банкнаас авсан зээл/Хөрөнгө оруулагчаас зээл/	-	385,692.0
Зээлийн төлөлт	-	(2,114.2)
Хүү ба урамшуулалтын орлого	-	57,750.0
Валютын ханшны зөрүү	-	1,093.2
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>480,990.2</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>63,507.4</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>1,232.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>64,740.1</b>

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн нэг саллигүй хэсэг болно